



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,
Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 23 50,
Цахим шуудан: info@pcsp.gov.mn,
Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2024.07.04 № А-1/1046
танай _____-ны № _____-т

**"АВТОТЭЭВРИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ"
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН
ГАЗРЫН ЗАХИРАЛ Б.ГҮРСОРОНЗОН
ТАНАА**

Ногдол ашиг төвлөрүүлэх тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн 11.1.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс улсын төсөвт төвлөрүүлэх төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн хувь хэмжээг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 351 дүгээр тогтоолоор баталсан бөгөөд "Автотээврийн үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын улсын төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг 2,835,503.01 мянган төгрөг байхаар тогтоосон.

Иймд дээрх хууль, тогтоомжийг хэрэгжүүлэн, төрийн өмчид ногдох ногдол ашгийг Сангийн яамны Төрийн сангийн улсын төсвийн орлогын ногдол ашгийн 100900000702 тоот дансанд төвлөрүүлж, гүйцэтгэлийг ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 351 дүгээр тогтоолыг хавсаргав.

Хавсралт 2 хуудастай.

ДАРГА



Б.ЦЭНГЭЛ



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2024 оны 07 сарын 04 өдөр

Дугаар 351

Улаанбаатар хот

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой
хуулийн этгээдийн 2024 оны Улсын төсөвт төвлөрүүлэх
төрийн өмчид ногдох хувьцааны ногдол ашгийн
хувь хэмжээг тогтоох тухай

Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5.1 дэх заалт, Монгол Улсын
2024 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг, Үндэсний баялгийн
сангийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.2.6, Төрийн болон орон нутгийн өмчийн
тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн 2023 оны
жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцлийн цэвэр ашгийн дүнгээс Улсын төсөвт
төвлөрүүлэх ногдол ашгийн хэмжээг хавсралт ёсоор тогтоосугай.

2. "Улаанбаатар төмөр зам" ХНН-ийн хувь нийлүүлэгчдийн хурлаар ногдол
ашгийн талаар шийдвэр гарсны дараа шийдвэрлэх арга хэмжээ авахыг Төрийн
өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн
удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТЭСИЙН
ДАРГА



Б.ЦЭНГЭЛ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газрын 2024 оны 07 дугаар сарын 04-ний
өдрийн 35/ дугаар тогтоолын хавсралт



ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦОРТОЙ ХУУЛИЙН
ЭТГЭЭДИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
ТЭНЦЛИЙН ЦЭВЭР АШГИЙН ДҮНГЭЭС УЛСЫН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛЭХ
НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭ

Д/д	Нэр	2023 оны цэвэр ашгийн дүн /мянган төгрөг/	Төрийн өмчийн ногдол ашиг /мянган төгрөг/
1	"Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ	9,451,676.70	2,835,503.01